



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/339

Улаанбаатар хот

“Халдварт өвчин судлалын үндэсний төвийн
дүрэм, зохион байгуулалтын бүтцийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дүрэм”-ийг нэгдүгээр, “Халдварт өвчин судлалын үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэц”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн орон тоог Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал С.Энхболдод даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/401 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141251865

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Халдварт өвчин судлалын үндэсний төв (цаашид "төв" гэх) нь улсын хэмжээнд халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, халдварт өвчний чиглэлээр лавлагаа шатлалын мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллах чиг үүрэг бүхий байгууллага юм.
- 1.2. Төв нь Монгол Улсын хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 1.3. Төв нь Олон улсын эрүүл мэндийн дүрэм (цаашид "ОУЭМД" гэх)-ийн зохицуулагч байгууллагын үүргийг үндэсний хэмжээнд гүйцэтгэн, эрүүл мэндийг дэмжих замаар хүн амыг халдварт өвчнөөс сэргийлэх, тархалтыг тандах, өвчлөл гарсан үед тархалтыг хязгаарлах, таслан зогсоох, томуу, томуу төст өвчин, улаанбурхан, сүрьеэ, ДОХ/БЗДХ, вирус, нян судлалын лабораториудын чиглэлээр лавлагаа төвийн үүргийг гүйцэтгэнэ.
- 1.4. Төв нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шууд удирдлагад харьяалагдан ажиллана.
- 1.5. Төв нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн баталсан стратеги төлөвлөгөөтэй байна.
- 1.6. Төв нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд санхүүгийн харилцах данстай байна.
- 1.7. Төвийн оноосон нэр : Халдварт өвчин судлалын үндэсний төв
 - Албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 13335, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо, Нам Ян Жугийн гудамж,
 - Утас: 7222-4444,
 - Цахим хуудасны хаяг: www.nccd.gov.mn
 - Цахим шуудангийн хаяг: info@nccd.gov.mn,
 - Иргэдэд мэдээлэл өгөх тусгай дугаар: 7222-4444, 100
- 1.8. Төвийн нэрийг англи хэл дээр "National Center for Communicable Diseases" гэж орчуулна.
- 1.9. Тусгай хэрэгцээт иргэний эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хууль тогтоомжийн дагуу бүрдүүлсэн байна.

ХОЁР. ТӨВИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Алсын хараа: Халдварт өвчнийг сөрөн тэсвэрлэх чадвартай Монгол Улсыг цогцлоох.

Эрхэм зорилго: Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэн, халдварт өвчний тандалт, сэргийлэлт, оношилгоо, эмчилгээнд дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлж, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, хүний нөөцийн тогтвортой хөгжил, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй хангана.

2.1 Төвийн зорилт:

- 2.1.1. Халдварт өвчний тандалтын үндэсний тогтолцоог бэхжүүлж, халдварт өвчнөөс сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг шуурхай, оновчтой зохион байгуулах;
- 2.1.2. Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах арга хэмжээг үндэсний хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, нэгж байгууллагуудыг мэргэжлийн арга зүйгээр хангах, дэмжлэгт хяналтыг тогтмолжуулах;
- 2.1.3. Халдварт өвчний чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлж, нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, орчин үеийн дэвшилтэт технологийг үе шаттай нэвтрүүлж, үндэсний хэмжээнд болон төвийн үйл ажиллагаанд өргөнөөр ашиглах;
- 2.1.4. Халдварт өвчний лабораторийн оношилгоо, лабораторит суурилсан тандалтын чадавхыг үндэсний хэмжээнд бэхжүүлэх;
- 2.1.5. Халдварт өвчний хяналт, сэргийлэлтийн чиглэлээр хүний нөөцийн ур чадварыг бэхжүүлэх.

2.2. Төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

- 2.2.1. Хууль, хүний эрхийг дээдлэх, ил тод байх;
- 2.2.2. Мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлсэн байх;
- 2.2.3. Ёс зүй, харилцаа хандлагыг эрхэмлэж, хариуцлагатай байх;
- 2.2.4. Хүний эрүүл мэнд, хувь хүн, байгууллага, төрийн нууцтай холбоотой мэдээллийн нууцыг чандлан хадгалах;
- 2.2.5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 2.2.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олон улсад болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, эмнэлзүйн зааврыг ашиглаж үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд ханган ажиллах;
- 2.2.7. Тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдэд чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;
- 2.2.8. Манлайлал, хөгжлийг эрхэмлэсэн суралцагч хамт олон байх.

ГУРАВ. ТӨВИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Төв нь дараах эрхтэй:

- 3.1.1. Халдварт өвчний асуудлаар улсын хэмжээнд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, эмнэлзүйн заавартай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- 3.1.2. Төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, хүний нөөц, материаллаг бааз, төсвийг бүрдүүлж, зохих хууль тогтоомж, журам, дүрмийн дагуу захиран зарцуулах, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн

захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал тавьж шийдвэрлүүлэх;

- 3.1.3. Олон улсын байгууллага болон хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулах;
- 3.1.4. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран явуулах, хурал, зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах, ном товхимол, зөвлөмж, заавар гаргах, нийтийн хүртээл болгох;
- 3.1.5. Нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал үүсэж болзошгүй үед шаардлагатай мэдээллийг хуулийн хүрээнд холбогдох байгууллага, албан тушаалтан, хувь хүнээс гаргуулах;
- 3.1.6. Мэргэжлийн онцлог асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнд мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа, сэрэмжлүүлэг өгөх, шаардлага тавих;
- 3.1.7. Төв нь хууль тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;
- 3.1.8. Хууль тогтоомжид заасан бусад эрх.

3.2. Төв нь дараах үүрэгтэй:

- 3.2.1. Төв нь чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийн хангах;
- 3.2.2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ОУЭМД-ийг баримтлан ажиллах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;
- 3.2.3. Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, тандалтын стандарт, эмчилгээний заавар, арга аргачлал боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- 3.2.4. Үндэсний хэмжээнд халдварт өвчний чиглэлээр эрүүл мэндийн болон бусад салбарын аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн арга зүйгээр хангах;
- 3.2.5. Үндэсний хэмжээнд халдварт өвчний чиглэлээр лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэх;
- 3.2.6. Бусад эрүүл мэндийн байгууллагаас холбогдох журмын дагуу шилжүүлсэн өвчтөнд төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, эмчилгээний зөвлөмж, дүгнэлт гаргах, үзүүлж буй тусламж, үйлчилгээ, оношилгоо, лабораторийн шинжилгээнд чанарын хяналт тавих, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх;
- 3.2.7. Төв нь тусламж, үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч, шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, ирсэн санал гомдолд дүн шинжилгээ хийж, залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 3.2.8. Тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологи болон мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх;

- 3.2.9. Төв нь эрхэлсэн асуудлын чиглэлээр болон байгууллагын үйл ажиллагаанд олон улсын түвшний чанарын итгэмжлэл, баталгаажилтыг авах;
- 3.2.10. Төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг үндэслэл, тооцоо судалгаанд тулгуурлан боловсруулах, батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтааж, байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж, хэрэгжүүлэх;
- 3.2.11. Төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтээх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх;
- 3.2.12. Халдварт өвчний чиглэлээр төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах;
- 3.2.13. Албан хаагчдын нийгмийн баталгаа, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах, мэргэжил, ур чадварт тохирсон цалин хөлс олгох, ажлын бүтээмж, үр дүнд суурилсан урамшуулал олгох, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах;
- 3.2.14. Албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлагыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, хэвшил болгох арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;
- 3.2.15. Төв нь үйл ажиллагаандаа авлига авах, өгөх, албан тушаалын байдлаа аливаа хэлбэрээр урвуулан ашиглах хууль бус үйлдэл, үйл ажиллагааг хориглох, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;
- 3.2.16. Жендерийн тэгш байдлыг хангах, бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, хүний эрхэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллах;
- 3.2.17. Хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах;
- 3.2.18. Эрүүл мэндийн багц хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, нийтэд сурталчлах;
- 3.2.19. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

ДӨРӨВ. ТӨВИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 4.1. Төвийг Захирал удирдана. Захирал нь гадаад, дотоод үйл ажиллагаанд төвийг төлөөлнө.
- 4.2. Төвийн удирдлагын тогтолцоо нь Захирал, Дэд захирал, Удирдлагын зөвлөлөөс бүрдэнэ.
- 4.3. Төв нь Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал, Халдварт өвчний тандалт, сэргийлэлт эрхэлсэн дэд захиралтай байна.
- 4.4. Төвийн дэд захирлууд өөрийн хариуцсан чиг үүргийг захирлын удирдлага дор гүйцэтгэж тайлагнан, хариуцлага хүлээнэ.

- 4.5. Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгж нь алба, тасаг байна. Нэгжийн удирдлага нь тухайн алба, тасгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавьж ажиллана.
- 4.6. Төвийн захирал нь дэд захирал, нэгжийн удирдлага, бусад төлөөллийг оролцуулсан Удирдлагын зөвлөл байгуулж, ажиллах журмыг батална.
- 4.7. Төв нь судалгаа, эрдэм шинжилгээний ажлын чиглэл, зорилтыг тодорхойлох, ажлын явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөл байгуулан ажиллуулж болно. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөс ирүүлсэн саналыг үндэслэн төвийн захирал батална.
- 4.8. Төв нь эрх бүхий байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо болон бусад шаардлагатай чиг үүрэг бүхий байнгын, түр хороо, зөвлөл, ажлын хэсгийг байгуулж ажиллана.
- 4.9. Төвийн захирал тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын шийдвэр, тогтоол, тэмдэглэл гаргана.

ТАВ. ТӨВИЙН САНХҮҮЖИЛТ

- 5.1. Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
 - 5.1.1. Улсын төсөв;
 - 5.1.2. Эрүүл мэндийн даатгалын сан;
 - 5.1.3. Үндсэн (хууль, тогтоомжоор зөвшөөрсөн төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого) болон үндсэн бус (хууль, тогтоомжид нийцүүлэн олсон бусад орлого) үйл ажиллагааны орлого;
 - 5.1.4. Төсвийн тухай хуулийн дагуу гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж, төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын орлого;
 - 5.1.5. Хууль, тогтоомжид заасан бусад эх үүсвэр.
- 5.2. Төв нь санхүүжилт, эд хөрөнгийг төвийн зорилго, зорилт, холбогдох хууль, тогтоомж, энэ дүрэмд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулан ашиглаж, ил тод байдлыг хангана.
- 5.3. Төв нь өөрийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үндсэн хөрөнгө бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, актлах саналаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 5.4. Төвийн эд хөрөнгийн тооллогыг Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тогтоосон хугацаанд, холбогдох журмын дагуу явуулна.
- 5.5. Төв нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гүйцэтгэж, аудит хийлгэж, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангана.
- 5.6. Төв нь өөрийн эд хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэл, тооцоонд тавих өөрийн болон хөндлөнгийн хяналтыг зохих хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 6.1. Төвийг гадаад, дотоод хамтын ажиллагаанд Төвийн захирал төлөөлнө.
- 6.2. Захирлын гадаад, дотоод албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.

- 6.3. Захирлын түр эзгүйд түүний албан үүргийг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал хэрэгжүүлнэ. Хэрэв Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал эзгүй бол Захирал өөрийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан тушаалтныг томилно.
- 6.4. Албан хаагчдыг гадаад, дотоодод албан томилолтоор ажиллуулах, суралцах асуудлыг төвийн захирал шийдвэрлэнэ.
- 6.5. Гадаад орны эрүүл мэндийн байгууллага, төвтэй хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулах замаар төвийн албан хаагчдыг сургах, дадлагажуулах, Олон улсын хуралд оролцох, хамтарсан судалгаа хийх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.6. Төв нь төрийн захиргааны төв байгууллагаас чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа бусад байгууллагатай уялдуулан ажиллана.
- 6.7. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

ДОЛОО. ТӨВИЙН ЗАХИРЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

7.1. Төвийн захирлын эрх:

Төвийн захирал нь Эрүүл мэндийн сайдтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд зааснаас гадна дор дурдсан эрхтэй. Үүнд:

- 7.1.1 Төвийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх;
- 7.1.2 Удирдлагын зөвлөлийн бүтэц, ажиллах журмыг батлан удирдан чиглүүлэх;
- 7.1.3 Хууль, тогтоомж бусад дүрэм, журмаар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал шийдвэр гаргах;
- 7.1.4 Төвийн алба, тасаг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг тодорхойлж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг батлах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих;
- 7.1.5 Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн эрх зүйн орчин болон хэтийн төлөвлөлттэй уялдуулан төвийн ажилчдын тоо, цалин хөлсийг тогтоох;
- 7.1.6 Дэд захирал, нэгжийн дарга болон ажилтнуудыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх;
- 7.1.7 Ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, сахилгын шийтгэл ноогдуулах, гэрээг цуцлах.

7.2 Төвийн захирлын үүрэг:

Төвийн захирал нь Эрүүл мэндийн сайдтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд тусгагдснаас гадна дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 7.2.1. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг төвийн хэмжээнд зохион байгуулах, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;
- 7.2.2. Төсвийн ерөнхийлөн захирагчаар жил бүр төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг салбарын урт, дунд, богино хугацааны бодлого, байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан батлуулж, хэрэгжилтийг хангаж, хагас, бүтэн жилээр тайлагнах, ил тод мэдээлэх;
- 7.2.3. Төвийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх алба, нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, уялдуулан зохицуулах;

- 7.2.4. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн эрх зүйн орчин болон хэтийн төлөвлөлттэй уялдуулан төвийн зүгээс үзүүлэх тусламж, үйлчилгээний цар хүрээ, тоо хэмжээг хүн амын хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөх;
- 7.2.5. Ажилтныг мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, тасралтгүй сургалтад хамруулах, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлаар гаргасан санал, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;
- 7.2.6. Төвийн үйл ажиллагааг сайжруулах санал, арга хэмжээний үр ашгийг тооцож, ашигтай хувилбарыг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх;
- 7.2.7. Батлагдсан төсөв, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан орон тоо, цалингийн санг зохицуулан ажиллах;
- 7.2.8. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, үйл ажиллагааны ил тод байдал, жендерийн мэдрэмжтэй байдлыг ханган, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;
- 7.2.9. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үед ажиллах байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо, гамшгийн шуурхай багийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, төлөвлөгөөг тухай бүр тодотгон баталж, шаардлагатай тохиолдолд идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах.

НАЙМ. ТӨВИЙН ДЭД ЗАХИРЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

8.1. Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал:

- 8.1.1. Хариуцсан нэгжүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, үр дүнг захирлын өмнө хариуцана;
- 8.1.2. Үйлчлүүлэгчдэд эелдэг, хөнгөн шуурхай үйлчлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, ёс зүйн хэм хэмжээг мөрдөх ажлыг зохион байгуулж, хяналт тавина;
- 8.1.3. Эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг мэргэжлийг тасралтгүй дээшлүүлж, эмчилгээний стандартын мөрдөлтийг хангаж, эмчилгээний чанар, үр дүнг сайжруулна;
- 8.1.4. Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт, хууль, тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг ёсчлон биелүүлж ажиллана;
- 8.1.5. Халдварт өвчний эмчилгээ, оношилгооны удирдамж, заавар боловсруулах үйл ажиллагааг мэргэжлийн арга зүйгээр хангаж, эдийн засгийн үр ашигтай, үр дүнтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ;
- 8.1.6. Үйл ажиллагааны тогтвортой байдал, жендерийн тэгш байдлыг хангах, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хориглох арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцож, авлигаас ангид ажиллана;
- 8.1.7. Төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллана;
- 8.1.8. Төвийн захирлын өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, ажлын хэсэг, нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог ханган, чиглүүлж, арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавина;
- 8.1.9. Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт, хууль, тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг ёсчлон биелүүлнэ.

8.2 Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал:

- 8.2.1 Хариуцсан нэгжүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, үр дүнг захирлын өмнө хариуцана;
- 8.2.2 Төвийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахад дэмжлэг үзүүлж, гүйцэтгэлд хяналт тавина;
- 8.2.3 Төвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа, хэрэглээний нэгдсэн судалгаанд суурилан үр ашигтай төлөвлөлт хийж, хэрэгжилтийг хангана;
- 8.2.4 Төвийн жил бүрийн төсвийн төслийг нотолгоонд үндэслэн боловсруулах үйл ажиллагааг удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар ханган ажиллана;
- 8.2.5 Үндсэн хөрөнгө болон бараа, материалын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж, эдийн засгийн үр ашигтай байдлыг хангана;
- 8.2.6 Гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төлөвлөх, хэрэгжилтийг ханган ажиллахад удирдлага зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ;
- 8.2.7 Үйл ажиллагааны тогтвортой байдал, жендерийн тэгш байдлыг хангах, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хориглох арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцож, авлигаас ангид ажиллана;
- 8.2.8 Төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллана;
- 8.2.9 Төвийн захирлын өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, ажлын хэсэг, нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог ханган, чиглүүлж, арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавина;
- 8.2.10 Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт, хууль, тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг ёсчлон биелүүлнэ.

8.3. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт эрхэлсэн дэд захирал:

- 8.3.1. Хариуцсан нэгжүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, үр дүнг захирлын өмнө хариуцана;
- 8.3.2. Нэг эрүүл мэнд зарчмаар төвийг төлөөлөн салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлнэ;
- 8.3.3. Халдварт өвчний тандалтын стандартыг мөрдлөг болгон халдварт өвчин тархахаас сэргийлэх, тандах, тархалтыг хязгаарлах, өвчлөлийг бууруулах арга хэмжээг үндэсний хэмжээнд мэргэжлийн арга зүйгээр хангана;
- 8.3.4. Халдварт өвчний дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах тандалтын тогтолцоог бэхжүүлж, ОУЭМД-ийн үндсэн чадавхыг бүрдүүлнэ;
- 8.3.5. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үед ажиллах байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо, гамшгийн шуурхай багийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, төлөвлөгөөг тухай бүр тодотгон батлуулж, шаардлагатай тохиолдолд идэвхжүүлэх ажлыг зохион байгуулж, тохиолдлын удирдлагын багийн даргад дэмжлэг үзүүлэн ажиллана;
- 8.3.6. Халдварт өвчнийг бууруулах, устгах нөхцөлийг бүрдүүлж, аюулгүй, чанартай вакцинаар хүн амыг дархлаажуулах, шинэ болон хавсарсан вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэх судалгаа, төлөвлөлтийг хийнэ;

- 8.3.7. Халдварт өвчнөөс сэргийлэх, тэмцэх талаар иргэдийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулж, үр дүнг тооцож, мэдээ, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлнэ;
- 8.3.8. Үйл ажиллагааны тогтвортой байдал, жендерийн тэгш байдлыг хангах, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хориглох арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцож, авлигаас ангид ажиллана;
- 8.3.9. Төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллана;
- 8.3.10. Төвийн захирлын өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, ажлын хэсэг, нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог ханган, чиглүүлж, арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавина;
- 8.3.11. Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт, хууль, тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг ёсчлон биелүүлнэ.

ЕС. ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖИЙН ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ

- 9.1 Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгж нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 9.1.1 Холбогдох хууль, тогтоомж, тушаал шийдвэр, стандарт, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, мөрдөж ажиллах;
- 9.1.2 Төвийн алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэхэд чиг үүргийн хүрээнд харилцан уялдаа холбоотой хамтран ажиллах;
- 9.1.3 Эрхэлсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны үр дүнг захирал, дэд захирлын өмнө хариуцах, тайлагнах;
- 9.1.4 Төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, авлигаас ангид ажиллах;
- 9.1.5 ОУЭМД-ийн үндсэн чадавхыг бүрдүүлэх
- 9.1.6 Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.
- 9.2 **Хүний нөөцийн хөгжил, сургалтын алба:** Төвийн хүний нөөцийн төлөвлөлт, чадварлаг, мэргэшлийн, ёс зүйтэй эмч, ажилтныг сонгон шалгаруулах, сургалтад хамруулах, нийгмийн баталгааг сайжруулах, цалин урамшууллыг нэмэгдүүлэх, алба, тасгийн хүний нөөцийн хуваарилалтыг батлагдсан орон тоо, төсөвтэй уялдуулан оновчтой зохион байгуулах, хүний нөөцийн тогтвортой хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.3 **Санхүүгийн алба:** Байгууллагын жилийн төсвийг үндэслэл сайтай төлөвлөж үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах, өр авлагагүй ажиллах, санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн актад нийцүүлэн зохион байгуулах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, санхүүгийн үйл ажиллагааны тайлан баланс, бусад мэдээ тайланг хуулийн хугацаанд нь тайлагнах, байгууллагын өмч, хөрөнгийн бүртгэл, бараа материал, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалтад хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 9.4 **Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн алба:** Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, эмчилгээ, оношилгоо, лабораторийн шинжилгээний чанарт хяналт тавих, мэргэжлийн арга зүйгээр хангах, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Төвийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрсдэлийг бүртгэх, эрэмбэлэх, эрсдлийн шалгуур үзүүлэлтийг батлах, үнэлэх, хариу арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан хаагч, үйлчлүүлэгчдэд соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

- 9.5 **Эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр, гадаад харилцааны алба:** Халдварт өвчний чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, судалгааны дүн, зөвлөмж боловсруулах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, олон улсын анагаах ухааны ололт амжилтыг нутагшуулах санал, зөвлөмж боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Байгууллагын гадаад харилцааны бодлогыг тодорхойлох, олон улсын болон гадаад улсын байгууллагуудтай үр ашигтай хамтарч ажиллах, гэрээ хэлцлийн төсөл боловсруулах, төрөл бүрийн төсөл, хөтөлбөрт хамрагдаж байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинарт оролцох, өөрийн оронд зохион байгуулах ажлыг зохион байгуулна.

- 9.6 **Талбарын тархвар судлалын алба:** Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах хүний нөөцийг үндэсний хэмжээнд бэлтгэх, орчин үеийн арга зүйгээр судалгаа хийж шийдвэр гаргалтад шаардлагатай нотолгоо бүрдүүлэх, үндэсний болон олон улсын талбарын тархвар судлал сургалтын төгсөгчдийн сүлжээгээр дамжуулан нийгмийн эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг сайжруулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 9.7 **Амбулаторийн тасаг:** Үйлчлүүлэгчийг хүлээн авч, бүртгэх, цаг товлох, эмчийн үзлэг оношилгоо хийх, онош тавих, шаардлагатай тохиолдолд лабораторийн болон дүрс оношилгоонд илгээх, эмийн болон эмийн бус эмчилгээ бичих, сайн дурын вакцинжуулалтыг зохион байгуулах, архаг өвчтэй хүмүүсийг хянах, эмчилгээний үр дүнг үнэлэх, хэвтүүлэн эмчлүүлэх тасагт шилжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 9.8 **Эрүүл мэндийг дэмжих, өдрийн эмчилгээний тасаг:** Үйлчлүүлэгчийг эмнэлэгт хэвтүүлэхгүйгээр тодорхой хугацаанд эмчилгээ, хяналт, сэргээн засах үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийг дэмжих, байгууллага, хамт олны урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах, жижиг мэс ажилбар хийх, эмийн болон физик эмчилгээ, хөдөлгөөн засал хийх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 9.9 **Онош зүйн тасаг:** Дүрс оношилгоо (рентген, хэт авиан шинжилгээ, компьютерт томографи, дурангийн шинжилгээ г.м.), багажийн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, эмчилгээний үр дүнг үнэлэх, эмчилгээний тактик сонгоход дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

9.10 Сувилахуйн алба: Төвийн хэмжээнд сувилахуй, эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах, гардан үйлдлийн стандарт, заавар, журмын хэрэгжилтийг хангах, хүний нөөцийн үр чадварыг тасралтгүй дээшлүүлж, улмаар тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

9.11 Эмчилгээний тасгууд: Төвийн эмнэлзүйн үндсэн бүтцийн нэгж бөгөөд хэвтүүлэн эмчлэх зайлшгүй шаардлагатай халдварт өвчтэй үйлчлүүлэгчийг хүлээн авч, эмийн болон эмийн бус эмчилгээ эмчилгээ хийх, сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмчилгээний үр дүнг үнэлэх, шаардлагатай тохиолдолд бусад тасаг, эмнэлэг рүү шилжүүлэх, эмчилгээ дууссан өвчтөнийг эмнэлгээс хяналтад гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

9.12 Төлөвлөлт, эдийн засаг, даатгал, статистикийн алба: Байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг салбарын бодлого, шийдвэртэй нийцүүлэн боловсруулах, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох, байгууллагын жилийн болон дунд хугацааны хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны нэгж өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах, жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, эмнэлгийн тусламж үйлчилгээг сурталчлах, иргэдэд болон албан байгууллагуудад хүргэх, тэдэнтэй харилцах харилцааг зохицуулах, дээрх асуудлаар байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Үндэсний түвшинд халдварт өвчний статистик мэдээ, мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, мэдээний сан бүрдүүлэх, бүртгэл, мэдээллийн талаар сургалт зохион байгуулах, бүртгэл мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих, цахим бүртгэл, бодит цагийн мэдээллийг нэвтрүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх үйл ажиллагааг хариуцна.

9.13 Хяналт-шинжилгээ, дотоод аудитын алба: Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, шаардлагатай үед байгууллагын тодорхой чиг үүрэгт үнэлгээ хийх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалтын үр ашигтай, зохистой байдалд дотоод аудит хийх, хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтийг үнэлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

9.14 Эмзүйн алба: Эмзүйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эмчилгээний өндөр идэвхтэй, чанарын баталгаатай, аюулгүй, эдийн засгийн үр ашигтай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангах, халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад нөөцийн бэлэн байдлыг хангах, эмийн жор бичилт, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, өвчин үүсгэгч эмэнд тэсвэржихээс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн

мэргэжилтэн, эмчлүүлэгчийг эмзүйн мэргэжлийн мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 9.15 **Мэдээлэл, технологийн алба:** Мэдээллийн аюулгүй байдал, эмнэлгийн цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээллийн технологийн зөөлөн болон хатуу дэд бүтцийг төлөвлөх хэрэгжүүлэх, шинэ цахим шилжилтийн бэлэн байдлын хангах, кибер аюулгүй байдал, нууцлал, мэдээний сангийн хадгалалтыг хариуцах, эмнэлгийн дотоод сүлжээ, сервер, компьютер, тоног төхөөрөмжийг суурилуулах, тохируулах засварлах, байгууллагын цахим бүртгэлийг хариуцах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.16 **Дэмжих алба:** Байгууллагын барилга байшин, эд хогшил, автомашин, эмнэлгийн тоног төхөөрөмж, мэдээлэл, холбооны тогтвортой үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, засвар үйлчилгээ хийх, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.17 **Хоол үйлдвэрлэлийн тасаг:** Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдийг эрүүл, аюулгүй эмчилгээний хоолоор хангах, халдварт өвчний онцлогт тохирсон хоол үйлдвэрлэлийн технологийг нэвтрүүлж ашиглах, хоолны илчлэг, шим тэжээлийн тэнцвэртэй байдлыг хангах, эмчийн зааврын дагуу тусгай дэглэмийн хоол бэлтгэх, хоол хүнсний аюулгүй байдал, стандартыг мөрдөх, эмнэлгийн ажилтнуудын хоолыг бэлтгэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.18 **Ариутгал, халдваргүйтгэлийн тасаг:** Төвд ашиглагдаж буй эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж, тасаг нэгжийн ариутгал, халдваргүйтгэлийг зохион байгуулах, ариутгалын чанарын стандартын хэрэгжилтийг хангах, эмнэлгийн дотоод халдвараас сэргийлэх, хог хаягдлын менежментийг хариуцах, халдварын хяналт сэргийлэлтийн талаар сургалт зохион байгуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.19 **Халдварт өвчний тандалт, судалгааны алба:** Халдварт өвчнийг хянах бодлого, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, халдварт өвчнөөс эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, халдварт өвчний гаралтыг бууруулах, өвчний голомтыг цомхотгон, тархалтыг таслан зогсоох, ОУЭМД-ийн үндэсний зохицуулагчийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлнэ. Улсын хэмжээнд томуу, томуу төст өвчин (ТТӨ)-ний тархвар судлалын болон вирүс судлалын тандалтыг зохион байгуулан хэрэгжүүлж, ТТӨ-ний тахалт болон цартахалт тархалтаас сэргийлэх, таслан зогсооход шаардагдах нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлзүйн арга хэмжээний үндэслэл, аргазүйг боловсруулах, энэ чиглэлээр ДЭМБ болон бусад орны томуугийн үндэсний төвтэй хамтран ажиллаж, мэдээлэл солилцох ажлыг хариуцна. Хүн амын дунд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулах ажлыг хариуцна.
- 9.20 **Шуурхай удирдлага, эрсдэлийн харилцааны алба:** Халдварт өвчний тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжээгүй үед халдварыг эрт илрүүлэх байнгын тандалтын үйл ажиллагаа явуулах, халдварт өвчний дэгдэлт, цартахлын эсрэг хариу арга хэмжээг төлөвлөн, бэлэн байдлыг хангах үйл

ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах; халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед шуурхай удирдлагын тогтолцоог батлагдсан журмын дагуу идэвхжүүлэн, хариу арга хэмжээг зохион байгуулах, бүх шатны эрүүл мэндийн байгууллага, бусад салбарын байгууллагыг мэргэжлийн арга зүйгээр хангах, нөхцөл байдлын болон эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах, хариу арга хэмжээний үр дүнг тогтмол үнэлж шаардлагатай тохируулга хийх, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын судалгаа шинжилгээ, хариу арга хэмжээний үндэсний чадавхыг бэхжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 9.21 **Сүрьеэгийн тандалт судалгааны алба:** Сүрьеэгийн чиглэлээр дэвшүүлсэн бодлогын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, хэрэгжүүлэх, хянах, үр дүнг тооцон сайжруулах ажлыг улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар ханган ажиллах ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Сүрьеэгийн тандалт, сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, хяналтын стандарт, заавар, аргачлал боловсруулж, эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулах тасралтгүй сургалтыг зохион байгуулна. Өвчлөл, тархалт, нас баралт, эмчилгээний үр дүнг тандан судалж, судалгаа эрдэм шинжилгээний ажлыг гүйцэтгэж, нотолгоонд суурилсан арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ. Хүн амын дунд сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулах ажлыг хариуцна.

Сүрьеэгийн төрөлжсөн мэргэшлийн лавлагаа тусламж үйлчилгээг үндэсний хэмжээнд үзүүлж, энэ чиглэлээр төр, хувийн хэвшлийн бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн нэгдсэн арга зүйгээр тасралтгүй ханган дуудлагаар болон телемедицинээр зөвлөгөө өгөх, цахим зөвлөгөөнийг зохион байгуулах замаар хамтран ажиллана. Сүрьеэгийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис, оношлуур захиалах, хүлээн авах, хадгалах, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулна.

- 9.22 **ХДХВ/ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны алба:** ХДХВ/ДОХ/БЗДХ-ын чиглэлээр дэвшүүлсэн бодлогын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, хэрэгжүүлэх, хянах, үр дүнг тооцон сайжруулах ажлыг улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар ханган ажиллах ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ХДХВ/ДОХ/БЗДХ-ын тандалт, сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, хяналтын стандарт, заавар, аргачлал боловсруулж, эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулах тасралтгүй сургалтыг зохион байгуулна. Өвчлөл, тархалт, нас баралт, эмчилгээний үр дүнг тандан судалж, судалгаа эрдэм шинжилгээний ажлыг гүйцэтгэж, нотолгоонд суурилсан арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ. Хүн амын дунд ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулах ажлыг хариуцна.

ХДХВ/ДОХ/БЗДХ-ын төрөлжсөн мэргэшлийн лавлагаа тусламж үйлчилгээг үндэсний хэмжээнд үзүүлж, энэ чиглэлээр төр, хувийн хэвшлийн бусад эрүүл

мэндийн байгууллагыг мэргэжлийн нэгдсэн арга зүйгээр тасралтгүй ханган дуудлагаар болон телемедицинээр зөвлөгөө өгөх, цахим зөвлөгөөнийг зохион байгуулах замаар хамтран ажиллана. ХДХВ/ДОХ/БЗДХ-ын оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис, оношлуур захиалах, хүлээн авах, хадгалах, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулна.

- 9.23 Нэгдсэн лабораторийн алба:** Халдварт өвчнийг лабораториор оношлох, эмчилгээний явцыг хянах шинжилгээ хийх, халдварт өвчний лабораторид суурилсан тандалт хийх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Үүсгэгчийг тогтоох микробиологи, нян судлал, ийлдэс судлал, молекул биологийн шинжилгээгээр лавлагаа үйлчилгээ үзүүлэх, халдварт өвчний лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай урвалж, оношлуурын тооцоо судалгааг гарган, нөөцийг бүрдүүлэх, лабораториудын чанарын гадаад хяналт хийх ажлыг зохион байгуулна.

Аймаг, дүүргийн лабораторийн үйл ажиллагааг мэргэжлийн арга зүйгээр хангах, заавар, гарын авлага боловсруулах, төгсөлтийн өмнөх болон дараах урт, богино хугацааны сургалтууд зохион байгуулах ажлыг хариуцна.

- 9.24 Дархлаажуулалтын алба:** Улсын хэмжээнд дархлаажуулалтын үйл ажиллагааг хариуцаж, тарилгатай халдварт өвчний тандалтын чиглэлээр бодлого, стратегийг тодорхойлж, нэгдсэн аргачлал, заавар, журам, стандарт боловсруулах, дархлаажуулалтын үр дүнг тархвар судлалын болон лабораторийн шинжилгээний аргаар тандах, судлах, улсын хэмжээнд шаардлагатай вакцины төлөвлөлт, захиалгыг хийж, нөөцлөх, хуваарилах, вакцинаар хангах, хадгалалт, тээвэрлэлт, аюулгүй дархлаажуулалт, тарилгат халдварт өвчний хөдлөл зүйд дүн шинжилгээ хийж, мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 9.25 Зөвлөл, хороод:** Төв нь Удирдлагын зөвлөл, Эрдмийн зөвлөл, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба, Ёс зүйн дэд хорооноос гадна дараах орон тооны бус зөвлөл, хороо, дэд хороодтой байна. Үүнд:

Эмнэлзүйн хороо нь эмнэлгийн мэргэжлийн багийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах, удирдлагаар хангах, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, алба, тасаг нэгжүүд болон хороодын үйл ажиллагааг хянах, алба, тасаг, нэгжийн тасралтгүй чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх, зорилго, зорилт, хүрэх арга замуудыг тодорхойлох чиг үүргийг зохицуулна.

Цус, цусан бүтээгдэхүүний дэд хороо нь цус цусан бүтээгдэхүүний захиалга, хадгалалтын горим, зохистой хэрэглээ, нөөцийн удирдлага, үл тохироо, алдаа, сургалт, сурталчилгаа хийх чиг үүргийг зохицуулна.

Эм зүйн дэд хороо нь эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээ, захилга, төсөв, үнийн санал, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн удирдлага, эмийн хордлого, мэдээлэл, зохистой хэрэглээ, сургалт, сурталчилгаа, эмийн сангийн үйл ажиллагааны хяналтыг зохицуулна.

Хоолны чанарын дэд хороо нь эмчилгээний хоол үйлчилгээний зохион байгуулалт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тасгийн стандарт, журмын мөрдөлтийг хянах, эмчилгээний хоолны нэр төрөл, чанар, технологийн гүйцэтгэлд болон хүнсний бүтээгдэхүүний худалдан авалт, чанар, хадгалалтад хяналт тавих, эмч, үйлчлүүлэгчдийн эмчилгээний хоолны талаарх мэдлэгийг дээшлүүлэх чиг үүргийг зохицуулна.

Хүний нөөцийн хороо нь салбарын хүний нөөцийн хууль, журмын хүрээнд хүний нөөцийн төлөвлөлт, хэрэгжилт, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, цалин урамшуулал, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааг зохицуулна.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын дэд хороо нь хөдөлмөрийн аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, эрсдэлийн үнэлгээ хийж хариу арга хэмжээ авах, хөдөлмөр аюулгүй байдлын зөрчлийг шийдвэрлэх, норм норматив тогтоох үйл ажиллагааг зохицуулна.

Эрсдэлийн удирдлагын хороо нь байгууллагын зорилго, зорилтод хүрэх явцад гарч болзошгүй эрсдэлүүдийг хянах, удирдах, учирч болзошгүй гэнэтийн эрсдэлээс санхүү, хүний нөөцийн байдлаа хамгаалах, төлөвлөх, хохирол багатайгаар даван туулах үйл ажиллагааг зохицуулна.

Үйлчлүүлэгчдийн зөвлөл нь үйлчлүүлэгч болон түүний ар гэрээс эмнэлгийн үйлчилгээний талаарх санал сэтгэгдлийг сонсон санал авч, хэрэгцээг тодорхойлж эмнэлгийн удирдлага, ажилчдад танилцуулан, төлөвлөлтөд тусгах үйл ажиллагааг зохицуулна.

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 10.1 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санаачилгаар салбарын бодлого чиглэлтэй уялдуулан дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.
- 10.2 Төвийн саналыг үндэслэн Эрүүл мэндийн тушаалаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 10.3 Энэхүү дүрэм нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталснаар хүчин төгөлдөр болно.
- 10.4 Төвийн дүрэм хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлснээр төвийн нийт албан хаагчид дагаж мөрдөнө
- 10.5 Энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгээр зохицуулна.

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

